



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2021 оны 01 сарын 12 өдөр

Дугаар 08

Мандалговь

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3 , аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр хэсгийн 1.2 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Төв халхын дуулалт жүжгийн театрт Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яамны хөрөнгө оруулалтаар хуваарилагдсан нийт 13,916,100 /арван гурван сая есөн зуун арван зургаан мянга нэг зуу/ төгрөгийн үнэтэй хавсралтад дурдсан 5 нэр төрлийн 13 ширхэг гэрлийн тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр: Төв халхын дуулалт жүжгийн театрын дарга (Д.Доржсүрэн)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

- 2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч, бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;
- 2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;
- 2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх;

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ

6

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр сарын
12 ний өдрийн 02 тогтоолын хавсралт

Төв халхын дуулалт жүжгийн театрын үндсэн хөрөнгөд бүртгэх
хөрөнгийн мэдээлэл

№	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Нэгж үнэ	Тоо	Дүн
1	Пистолит гэрэл	ш	5,179,900	1	5,179,900
2	Мак гэрэл	Ш	1,260,600	2	2,521,200
3	Гэрлийн удирдлага	ш	2,099,900	1	2,099,900
4	Лед гэрэл	Ш	471,900	5	2,359,500
5	Лед гэрэл	ш	438,900	4	1,755,600
Тоног төхөөрөмжийн дүн				13	13,916,100